



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/598

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон Хөвсгөл аймгийн Засаг даргын хооронд төрийн зарим чиг үүргийг 2024 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний 2.52, 2.81 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулиудын хэрэгжилтэд үнэлгээ хийх, үзлэг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Улсын үзлэг зохион байгуулахад шаардагдах 1,097,500 (Нэг сая ерэн долоон мянга таван зуу) төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, удирдлага хөтөлбөрийн Хөдөлмөрийн хамтын гэрээ хэлэлцээрийг бүртгэж, үйл ажиллагааг дэмжих арга хэмжээний зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3.Дээрх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, тайланг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Цэцэгмаа)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024
оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн
А/596 дугаар захирамжийн хавсралт

УЛСЫН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Цэцэгмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга)

Гишүүд:

Б.Базардамбуу (Статистикийн хэлтсийн дарга)

М.Даваадулам (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого,
үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн)

А.Цэнд-Аюуш (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн
эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч)

Ц.Баярцэнгэл (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн
хяналтын улсын байцаагч)

Б.Золбоо (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн
хяналтын улсын байцаагч)

А.Баярмаа (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн
харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн)

Н.Отгонбаяр (Ажил олгогч эздийн холбооны тэргүүлэгч)

Ц.Ганболд (Хөвсгөл аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга)

Ө.Уранчимэг (Нэгдсэн эмнэлгийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга)

Нарийн бичгийн дарга:

Т.Раднаабүд (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

оОо